

Бага насны хүүхдийн бичиг үсгийн боловсролд гэр бүлээс үзүүлэх дэмжлэг, боломж

Б.Төртогтох

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Арга зүйн тэнхим

Хураангуй

НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтуудын дөрөвдүгээрт насан туршийн суралцах боломжийг дэмжсэн баталгаатай, чанартай боловсролын тухай байдаг. Хүмүүний насан туршийн бие даан суралцах чадвар эзэмшихэд цэцэрлэг, гэр бүл, хүрээлэн буй орчны олон хүчин зүйлс нөлөөлж байдаг. Манай багш, эцэг эх, асран хамгаалагчид бага насны бичиг үсгийн боловсролыг сургуульд элсэн суралцахад бэлэн байх төдийгөөр ойлгож байдаг ч дэлхий дахинаа уншиж, бичихийн өмнөх чадвар хэмээн хүлээн авч, анхаарлаа хандуулж байна. Энэхүү өгүүлэл нь бага насны хүүхдийн бичиг үсгийн боловсролын тухай орчин үеийн чиг хандлагын тухай ойлголтыг монгол эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэгийг сорьсон судалгааны үр дүнгийн хамт танилцуулах болно. Судалгааг бага насны бичиг үсгийн боловсролын суурь чадвар болсон авиан тухай ойлголт, үсгийн тухай ойлголт, бичгийн тухай ойлголт ба бичих сонирхол, үгийн нөөц, ярих чадвар гэсэн үндсэн чадваруудад тулгуурлан боловсруулсан асуулт бүхий асуулгын аргаар, Улаанбаатар хотын цэцэрлэгт хамрагддаг 5 настай хүүхэдтэй эцэг эхчүүдээс санамсаргүй байдлаар түүвэрлэн авч судалж үзлээ. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 55% нь гэртээ хүүхдийнхээ бичиг үсгийн чадварыг дэмжсэн үйл хийдэг болох нь батлагдсан хэдий ч эдгээр нь хүүхдийн насан туршийн суралцахуйн чадварыг дэмжихэд төдийлөн чиглэгдэхгүй байгаа нь харагдсан юм. Хүүхдийн унших, бичих хүсэл сэдлийг өдөөсөн гэр бүлийн орчин, түүнд нийцсэн эцэг эхийн дэмжлэг нь хүүхдийн унших бичих хүслийг өдөөж, чадварыг дэмжиж улмаар насан туршдаа уншиж судлах, суралцах хүсэлд хөтөлдөг. Ийм урьдач, үнэ цэнтэй гэр бүлийн орчин, эцэг эхийн дэмжлэгийг илрүүлснээр бид бага насны боловсрол, бага насны бичиг үсгийн боловсролын онол, арга зүйн асуудалд өчүүхэн хувь нэмэр оруулах боломж бүрдэнэ.

Түлхүүр үг

Бага насны бичиг үсгийн боловсрол, гэр бүлийн бичиг үсгийн орчин, эцэг эхийн ойлголт, эцэг эхийн дэмжих үйл ажиллагаа

Удиртгал

Нийгмийн аливаа үзэгдлийн чанарын цаана түүний дотоод мөн чанар нь хөдөлгөгч хүч нь болж байдаг нь байгалийн жам. Хүний хөгжлийн зүй тогтол ч мөн адил, хүний өөрийн идэвхтэй бие даан суралцах, бүтээх чадвар байдаг ба чухамхүү энэ чадварыг хүн бага насандаа эзэмшдэг аж.

Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (ТХЗ) нь илүү хөгжингүй, бүтээлч ирээдүйг бүтээх төлөвлөгөө бөгөөд нэг зорилтод нь XXI зууны иргэн нь насан туршийн суралцагч байх тухай заасан байдаг. НҮБ-ын сайтад тэмдэглэснээр өнөөдөр дэлхий дээр 265 сая хүүхэд сургууль завсардаж байгаа бөгөөд үүний 22 хувь нь бага боловсролын насны хүүхдүүд байна. Сүүлийн арван жилийн хугацаанд боловсролын бүх түвшний хамрагдалт, элсэлтийн хувь өссөн хэдий ч чанартай боловсролын асуудал хэн бүхний санаа зовоосон асуудлын нэг хэвээр байсаар

байна. Үүнд мэргэшсэн багш, боловсролын байгууллагын орчны нөхцөл, ар гэрийн нөхцөл байдал гээд олон хүчин зүйлс нөлөөлж байдаг.

Бага насны бичиг үсгийн боловсролын тухай ойлголт

Бага насны бичиг үсгийн боловсрол гэдэг нь хүүхдийн уншиж бичиж сурах тухай ойлголт огтоос биш бөгөөд хүүхдийн уншиж бичихийн өмнөх бэлтгэл юм (McNaughton 1995; Reese et al. 2003; Sulzby and Teale 1991). Өөрөөр хэлбэл, бага насны хүүхдэд уншиж бичихийн өмнө урьдач бэлтгэл хэрэгтэй байдаг ба хэдийгээр нэгдмэл нэгэн саналд хүрээгүй байгаа хэдий ч (Rhyner et al. 2009, p 7) дэлхий дахинаа дараах 5 чадвараар бага насны боловсролыг тодорхойлж байна. Үүнд:

- Авиан тухай ойлголт
- Үсгийн тухай ойлголт
- Бичгийн тухай ойлголт, бичих хүсэл

сонирхол

- Үгийн нөөц
- Ярих чадвар

Хүүхэд хэдий чинээ бага наснаасаа унших бичихийн ач холбогдлыг амьдрал дээр биеэр мэдэрч, ойлгож, ухаарах тусам төдий чинээ мэдэх, чадахын амтыг мэдэрч, өөрөө бие даан суралцах, улмаар дараа дараагийн боловсролын шатанд өөрийгөө бэлтгэх замаар насан туршийн суралцагч болж төлөвшдөг. Чухам үүгээр л бага насны бичиг үсгийн боловсролын ач холбогдол тайлбарлагдах учиртай.

Эрдэмтэн, судлаачид хүүхдийн бичиг үсгийн боловсролын мөн чанарыг ойлгох, бага насны аман ярианы чадвар унших чадвартай хэрхэн харилцан уялддаг, үүгээр хожмын унших, бичих чадварыг урьдчилан таамаглах боломжийг олж харахыг хичээсэн олон арван судалгааг хийж хийж байна.

Бага насны бичиг үсгийн чадварт эцэг эхийн үзүүлэх нөлөөлөл

Бага насны боловсролын мэргэжилтнүүд гэр бүлийн бичиг үсгийн боловсролын орчин хүүхдийн хэлний хөгжил, бичиг үсгийн чадварт чухал нөлөө үзүүлдгийг хүлээн зөвшөөрдөг (Burgess 2011; Foy and Mann 2003; Phillips and Lonigan 2009; Rodrigues and Tamir-LeMonda 2011). Бага насны хүүхдийн бичиг үсгийн чадвар эзэмшихэд эцэг эхийн зүгээс үзүүлэх дэмжлэг гэдэгт гэр бүлийн өргөн хүрээ, агуулга бүхий үйл ажиллагааг хамруулан ойлгох бөгөөд үүнд хүүхдийн гэрт байх ном (Breit-Smith et al. 2010; Fritjers et al. 2000; Johnson et al. 2008; Rodriguez and Tamir-LeMonda 2011; Weigel et al. 2006; Wood 2002), хүүхэдтэйгээ хамтран ном үзэх, унших (Schmitt et al. 2011; van Steensel 2006; Weigel et al. 2006; Wood 2002), хамтдаа дуу дуулах, үлгэр ярих, гэр бүлийн үйл ажиллагааг хамтдаа төлөвлөх, хийх зэрэг гэр бүлийн өдөр тутмын энгийн үйлүүд байх ба эдгээр нь бага насны хүүхдийн бичиг үсгийн чадвар эзэмшихэд, сурах сонирхолд эерэг нөлөө үзүүлдэг (Passenger et al. 2000; Wood 2002; Wood and Terrell 1998 а, б) хамгийн чухал хүчин зүйл болдог. Жишээлбэл, дээр дурдсан гэр бүлийн үйл ажиллагаануудад оролцдог хүүхдийн үгийн нөөцийн хэмжээ оролцдоггүй хүүхдийнхээс хавьгүй илүү байсныг (Hart and Risley 1995; Hoff et al. 2002; Lawrence and Shipley 1996) баталсан судалгаанууд байдаг. Мөн хүүхдийг бичиг үсэгтэй холбоотой үйл ажиллагаанд татан оролцуулж байх нь түүний унших чадвар төдийгүй, бичиг үсгийн тухай ойлголтыг дэмжиж, өргөтгөж байдаг (Farver et al. 2013; Niklas and Schneider 2013). Гэртээ бичиг

үсгийн холбоотой үйл ажиллагаанд оролцож байсан хүүхдийн хэлний хөгжил болон бичиг үсгийн талаарх ойлголт, сонирхол хожмын амьдралд нь ч мөн нөлөөлж байдаг ба энэ оролцооны байдал хүүхдийн ар гэрийн орлогын түвшин, эцэг эхийн боловсролын түвшингээс хамааралтай байдаг нь зарим судалгаануудын дүгнэлтэд харагддаг (Dale et al. 2003; Hart and Risley 1995; Rescorla 2005). Хүүхдийн гэр бүлийн орчин, эцэг эхийн боловсролын түвшин, цалингийн орлогын түвшин зэрэг үзүүлэлтүүд хүүхдийн аман яриа (Farver et al. 2008; Johnson et al. 2008; Payne et al. 1994; Schmitt et al. 2011), үгийн нөөц (Farver et al. 2008; Johnson et al. 2008; Kim 2009; Schmitt et al. 2011; van Steensel 2006) зэрэг бичиг үсгийн чадваруудын хөгжилд нөлөөлөх хамаарлыг судалсан судалгаанууд олон байдаг. Гэхдээ чухам ямар үйл ажиллагаа хүүхдийн бичиг үсгийн ямар чадварыг дэмжиж, нөлөөлж байгааг судалж хараагүй тайлбарлаагүй байгаа хэдий ч цаашид үүнийг судлах шаардлага байгааг бага насны судлаачид хүлээн зөвшөөрдөг (Kim. 2015).

Бага насны бичиг үсгийн чадварын талаарх эцэг эхийн ойлголтын судалгаа Түүврийн сонголт

Энэхүү судалгааны түүврийг дараах шалгуураар сонгож авлаа: хүүхэд нь (i) улсын цэцэрлэгт явдаг байх, учир нь улсын цэцэрлэгийн эцэг эхчүүд боловсролын болон орлогын түвшний хувьд харилцан адилгүй байх магадлал өндөр, (ii) бэлтгэл бүлэгт явдаг байх, учир нь сургуульд орох дөхсөн хүүхэдтэй эцэг эхчүүд бага насны бичиг үсгийн боловсролын талаар илүү ойлголттой байх зэргийг харгалзан үзэж, санамсаргүй байдлаар сонгож хамрууллаа.

Арга зүй

Бага насны бичиг үсгийн боловсролын талаарх эцэг эхийн мэдлэгийг дээр дурдсан 5 чадварын хүрээнд хийгдэх үйлийг хийдэг эсэх талаар асуулгын аргаар судаллаа. Асуулгад хүүхэдтэйгээ гэр бүлийн орчинд хийх үйлийг 15 асуултаар, долоо хоногт давтагдах давтамжийг 4 асуултаар судалж үзлээ. Ингэхдээ бага насны бичиг үсгийн боловсролын талаарх эцэг эхийн ойлголт, мэдлэгийг:

- Хүүхдийн авиан тухай ойлголтын талаарх эцэг эхийн мэдлэгийг (i) Та хүүхдийнхээ буруу дуудсан авиаг засаж, дангаар болон үгэнд орсон байдлаар давтан дуудуулдаг уу, (ii) Та хүүхэдтэйгээ үгэнд орсон авиаг сольж хэлүүлэх, утгыг ярилцдаг уу, (iii) Та хүүхэдтэйгээ үгэн тоглоомоор тоглодог уу,


- (iv) Та хүүхэдтэйгээ хамт дуу дуулдаг уу гэсэн асуултуудаар;
- b. Хүүхдийн үсгийн болон бичгийн тухай ойлголтыг номтой холбосон (i) Та гэртээ хүүхэдтэйгээ хамт ном уншдаг уу, (ii) Та хүүхэдтэйгээ номын дэлгүүр рүү зорьж явдаг уу, (iii) Та хүүхэддээ номын зураг болон бичвэрийн хэсгийг харж ярилцдаг уу, (iv) Гэрт тань хүүхдийн гар хүрэх газар үзэх ном нь байдаг уу гэсэн асуултуудаар;
- c. Хүүхдийн бичих хүсэл сонирхлыг дэмжих тухай эцэг эхийн ойлголтыг (i) Та дэлгүүрээс худалдан авах зүйлсийн жагсаалтаа хүүхэдтэйгээ хамт гаргадаг уу, (ii) Та хүүхэддээ зурвас бичиж үлдээдэг үү, (iii) Гэрт тань хүүхдийн гар хүрэх газар бичих хэрэгсэл байдаг уу гэсэн асуултуудаар;
- d. Хүүхдийн үгийн нөөцийг өргөжүүлэх, сайжруулах тухай эцэг эхийн ойлголтыг (i)

Та гэртээ хүүхэдтэйгээ хамт ном уншдаг уу, (ii) Та хүүхэдтэйгээ нийтийн газрын тэмдэг тэмдэглээний талаар ярилцдаг уу, (iii) Та хүүхдийнхээ мэдэхгүй байгаа үгийн утгыг тайлбарлаж өгдөг үү, (iv) Та хүүхэддээ номын зураг болон бичвэрийн хэсгийг харж ярилцдаг уу гэсэн асуултуудаар;

- e. Хүүхдийн ярих чадварыг дэмжих тухай эцэг эхийн ойлголтыг (i) Та хүүхэдтэйгээ уншсан ном, үзсэн киноны талаар ярилцдаг уу, (ii) Та хүүхэдтэйгээ нийтийн газрын тэмдэг тэмдэглэсний талаар ярилцдаг уу, (iii) Та хүүхэддээ номын зураг болон бичвэрийн хэсгийг харж ярилцдаг уу, (iv) Та хүүхэдтэйгээ үгэн тоглоомоор тоглодог уу гэсэн асуултуудаар тус тус илрүүлэхээр асуулгын хуудсыг боловсрууллаа.

Боловсруулалтыг энгийн математик боловсруулалтын аргаар боловсруулж, үр дүнг нэгтгэн дараах байдлаар харлаа.

Үр дүн



Дээрх диаграммаас харахад:

- Хүүхдийг авиан тухай ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг авиа дуудлагыг засдаг, авиа болон үгийг давтан дуудуулдаг, хүүхэдтэйгээ хамтдаа дуулдаг гэж судалгаанд оролцсон бүх эцэг эхчүүд хариулсан нь тэд хүүхдийнхээ цэвэр тод дуудлагад ихээхэн анхаарал хандуулдаг болохыг харуулж байна. Гэвч авиан тухай ойлголтыг олж авах үгэн дэх авианы тухай ойлгох үгэн тоглоом, үгэн дэх авиаг сольж хэлүүлэх үйлийг төдийлөн хийлгэдэггүй (34%) болох нь энэ тухай эцэг эхийн ойлголт тааруу байгааг харуулж байна. Гэтэл авиаг цэвэр тод дуудаж сурахаас гадна

өөрийн болон өрөөлийн хэлж буй авианы ялгаатай байдал, авиа өөрчлөгдөхөд үгийн утгад гарч буй өөрчлөлт, авиаг тэмдэгт буюу үсгээр тэмдэглэдэг, нэг үг хэд хэдэн авианаас бүтдэг зэргийг мэдэх нь хүүхдийн бичиг үсгийн чадварыг дэмжих нэг үндсэн чадвар болдог.

- Мөн гэр бүлийн орчинд бүх хүүхдийн гар хүрэх газар үзэх дуртай ном болон бичих хэрэгсэл байрладаг гэсэн үзүүлэлт 100% гарсан нь хүүхэд дуртай үедээ ном үзэх, бичих боломж байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь хүүхэд албадлагагүйгээр, хүссэн сонирхсон үедээ өөрийгөө сорих,

дадлагажих боломжоор хангаж байгаа бас нэг эерэг хандлагын үзүүлэлт юм.

- Судалгаанд оролцогчдын 19% нь дэлгүүрээс авах зүйлсийн жагсаалтыг хүүхэдтэйгээ хамтран гаргадаг, 15% нь хүүхэддээ зурвас бичиж үлдээдэг, 13% нь л гудамж талбай, дэлгүүрийн хаяг тэмдэг, тэмдэглэгээг хүүхэдтэйгээ харж ярилцдаг нь харин уншиж бичиж сурахын ач холбогдлыг амьдрал практикт олж харж, ухаарч ойлгох боломжийг өгдөг болохыг эцэг эхчүүд төдийлөн сайн мэдэхгүй байгааг харуулж байна.

- Судалгаанд оролцогчдын хагасаас илүү хувь (55%) нь хүүхэдтэйгээ хамт ном уншдаг хэдий ч энэ нь ихэвчлэн (55%-н 29% нь) долоо хоногт 1-2 удаа байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм. Харин судалгаанд оролцогчдын 23% нь хүүхэдтэйгээ номын дэлгүүр рүү зорьж явдаг, 29% нь номын утга агуулга, зураг бичгийнх нь талаар ярилцдаг нь хүүхдийн хөгжил, төлөвшил, хожмын сурах үйлд үзүүлэх нөлөөллийн ач холбогдлыг мөн ухаж ойлгоогүй, зорилго чиглэлтэй үйл ажиллагаа дутагдаж байгааг харуулж байна.

Хүүхэд эцэг эхийн хамтдаа хийдэг үйлийн давтамжийг дараах хүснэгтээс харж болно.

	Хүүхэдтэйгээ хамт ном уншдаг	Хүүхэдтэйгээ номын дэлгүүр явдаг	Хүүхэддээ зурвас бичиж үлдээдэг	Хүүхэдтэйгээ хамт дуу дуулдаг
Үгүй	45%	77%	85%	
Долоо хоногт нэг ба хоёр удаа	29%	4%		43%
Долоо хоногт 3-6 удаа	16%			36%
Өдөр бүр	10%			21%
Хааяа		19%	15%	

Эндээс харахад:

- Бүх эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамт дуу дуулдаг боловч давтамж нь төдийлөн сайн биш байгаа нь судалгаанд оролцогчдын 21% буюу 1/5 нь л өдөр бүр хамтдаа дуу дуулдаг байна.
- талаас илүү хувь (55%) нь хүүхэдтэйгээ хамтран ном уншихад тодорхой цаг хугацааг гаргадаг байхад, 10 % нь үүнийг өдөр тутмын тогтмол үйл ажиллагаа болгосон байгаа нь бас л чамлалттай үзүүлэлт юм. Энэ нь дээр дурдсанчлан эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамт ном уншихын ач холбогдлыг төдийлөн мэдэхгүй байгааг харуулж байна.
- Уншиж, бичиж сурах нь амьдралд ямар хэрэгтэйг бодитоор үлгэрлэн харуулах боломж бүхий үйлүүдэд хүүхдээ оролцуулдаггүй нь судалгаанд оролцогчдын 15%-19% нь л хүүхэдтэйгээ номын дэлгүүр рүү зорьж явдаг, хүүхэддээ зурвас бичиж үлдээдэг гэсэн үзүүлэлтээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, амьдралын бодит үйлд хүүхдээ төдийлөн оролцуулдаггүй болох нь харагдаж байна.

Дүгнэлт

Дээрх онолын болон эмперик судалгаанаас дараах дүгнэлтийг гаргаж болохоор байна.

Үүнд:

- Энэхүү судалгааны асуулгад багтсан агуулгаас харахад бага насны боловсролын талаар эцэг эхийн ойлголт 54.8% гэсэн дундаж үзүүлэлттэй гарсан хэдий ч энэ нь мөн чанартаа хүүхдээ сургуульд бэлтгэх гэсэн зорилготой байгаа байдал харагдаж байна. Гэтэл бага насны бичиг үсгийн боловсролын тухай ойлголт нь хүүхдийг сургуульд бэлтгэх төдий асуудал биш, харин насан туршийн бие даасан, бүтээлч идэвхтэй суралцагч байх тухай асуудал юм.
- Бага нас гэдэг хүний амьдралын хамгийн уян, хурдацтай хөгжлийн үе төдийгүй бодит үйлээр дамжуулан аливааг ухаарч ойлгож байдаг онцлогтой нас. Ийм үед нь бид аливаа асуудлын мөн чанар, зүй тогтлыг хэлж өгөх бус бодит үйлээр ухамсарлах боломжийг бүрдүүлэх нь энэ насны суралцагчтай ажиллах мэргэжилтэн, эцэг эхийн үүрэг юм. Үүнд бага насны боловсролын мэргэжилтэн, эцэг эхийн хамтын зорилго чиглэлтэй үйл ажиллагаа дутагдаж байна.
- Энэхүү судалгаанд яригдаж байгаа бидний үр хүүхэддээ цаг гаргаж буй байдал нь өнгөц харахад хүүхэд шиг, маш энгийн үйлүүд харагдаж байгаа хэдий ч бодолхийлэн гүн рүү өнгийгөөд харвал ерөнхий боловсролын дунд сургууль, дээд сургуулийн суралцагчдаас хүсээд байгаа бүтээлч, идэвх сонирхолтой, бие даасан насан туршийн суралцагч байхын

үндэс суурь энд байгааг ухаарч болно.

Хязгаарлалт ба цаашдын судалгааны чиглэл

Энэхүү судалгааны асуулгын агуулга нь бага насны бичиг үсгийн боловсрол, чадварын талаарх бүхий л агуулгыг хамруулаагүй бөгөөд үүнийг цаашид илүү хөгжүүлэн боловсруулж, сургуулийн өмнөх боловсролын салбарын хүрээнд ашиглагдах боломжтой судалгааны арга зүй, аргачлал боловсруулах шаардлага зүй ёсоор мэргэжилтэн бидний өмнө тавигдаж байна.

Практикт хэрэгжүүлэх боломж

Энэхүү судалгаань бичиг үсгийн чадварыг дэмжсэн гэр бүлд суурилсан үйл ажиллагааг идэвхжүүлэх боломж хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад байгааг харуулж байгаагаас гадна гэр бүлийн орчноор дамжуулан хүүхдийн унших, бичих чадварыг хэдий чинээ эрт дэмжинэ төдий чинээ хүүхдийн сурах хүсэл сонирхлыг тэдний эцэг эхийн боловсрол, орлогын түвшингээс хамаарахгүйгээр дэмжих боломжтой юм. Бусад олон судалгаанаас хүүхдийн үгийн нөөцийн болон аман ярианы хөгжлийн ялгаатай байдлаас шалтгаалан хүүхдийн бичиг үсгийн чадварт мөн ялгаатай байдал үргэлжилсээр байдгийг (Farakas and Beron 2004; Hart and Risley 1995; Hoff 2006, 2009; Rodriguez and Tamis-LeMonda 2011) бидний энд дэвшүүлж буй санаагаар шийдвэрлэх боломж бүрдэнэ. Ийм учраас гэр бүлийн орчинд хүүхдийн бичиг үсгийн чадварыг дэмжих эцэг эхийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх нь сургуулийн өмнөх боловсролын байгууллага, мэргэжилтнүүдийн өмнө нэн тулгамдсан ажлын нэг болоод байна.

Ном зүй

- Breit-Smith, G., Cabell, S. Q., & Justice, L. M. (2011). Home literacy experiences and early childhood disability: A Descriptive study using the National Household Education Surveys (HNES) Program Database. *Language, Speech, and Hearing Services in Schools*, 41, 96-107. doi:10.1044/0161-1461(2007/023).
- Burgess, S. R. (2011). Home Literacy environment (HLEs) provided to very young children. *Early Child Development and Care*, 181, 445-462. doi:10.1080/03004430903450384.
- Dale, R. S., Price, T. S., Bishop, D. V. M., & Plomin, R. (2003). Outcomes of early language delay: I. Predicting persistent and transient language difficulties at 3 and 4 years. *Journal of Speech, Language, and Hearing Research*, 46, 544-560. doi:10.1044/092-4388(2003/044).
- Hart, B., & Risley, T. R. (1995). *Meaningful differences in the everyday experiences of young American children*. Baltimore: Brookes.
- Hoff, E., Laursen, B., & Tardif, T. (2002). Socioeconomic status and parenting. In M. Bornstein (Ed.), *Handbook of parenting: Vol. 2. Biology and ecology of parenting* (2nd ed., pp. 231-252). Mahwah, NJ: Lawrence Erlbaum.
- Johnsons, G. D., Martin, G., Brooks-Gunn, J., & Petrill, S. A. (2008). Order in the house: Associations among household chaos, the home literacy environment, maternal reading ability, and children's early reading. *Merrill-Palmer Quarterly: Journal of Developmental Psychology*, 54, 445-472. doi:10.1353/mpq.0.0009.
- Lawrence, V., & Shipley, E. F. (1996). Parental speech to middle and working class children from two racial groups in three setting. *Applied Psycholinguistics*, 17, 233-256. doi:10.1017/S0142716400007657.
- Kim, S., Im, H., Kyong, K. (2015). The Role of Home Literacy Environment in Toddlerhood in Development of Vocabulary and Decoding Skills. *Journal of Child Youth Care Forum: Springer*. doi:10.1007/s10566-015-9309-y.
- McNaughton, S. (1995). *Patterns of emergent literacy: Processes of development and transition*. New York: Oxford University press.
- Rhyner, P. A., Haebig, E. D., & West, K. B. (2009). Understanding frameworks for the emergent literacy stage. In P.M. Rhyner (Ed). *Emergent literacy and language development* (pp. 5-35). New York: Guilford Press.
- Farver, F. A. M., Xu, Y., Lonigan, C. J., & Eppe, S. (2013). The home literacy environment and Latino head start children's emergent literacy skills. *Developmental Psychology*, 49, 775-791. doi:10.1037/a0028766.
- Foy, J. G., & Mann, V. (2003). Home literacy environment and Phonological awareness in preschool children: Differential affects for rhyme and phoneme awareness. *Applied Psycholinguistics*, 24, 59-88. doi:10.1017/S0142716403000043.
- Fritjers, J. C., Barron, R. W., & Brunello, M. (2000). Direct and mediated influences of home literacy and literacy interest on pre-readers' oral vocabulary and early written language skill. *Journal of Educational Psychology*. 92, 466-477. doi:10.1037/0022-0663.92.3.466.
- Niklas, F., & Schneider, W. (2013). Home literacy environment and the beginning of reading and spelling. *Contemporary Educational Psychology*, 38, 40-50. doi:10.1016/j.cedpsych.2012.10.001.
- Passenger, T., Stuart, M., & Terrell, C. (2000).

- Phonological processing and early literacy. *Journal of Research in Reading*, 23, 55-66. doi:10.1111/1467-9817.00102.
- Phillips, B. B., & Lonigan, C. J. (2009). Variations in the home literacy environment of preschool children: A cluster analytic approach. *Scientific Studies of Reading*, 13, 146-174. doi:10.1080/10888430902769533.
- Rescorla, L. (2005). Age 13 language and reading outcomes in late-talking toddlers. *Journal of Speech, Language, and Hearing Research*, 48, 459-472. doi:10.1044/1092-4388(2005/031).
- Rodriguez, E. T., Tamis-LeMonda, C. S., Spelman, M., Pan, B., Paikes, G., Lugo-Gil, J., & Luz, G. (2009). The formative role of home literacy experience across the first three years of life in children in low-income families. *Journal of Applied Developmental Psychology*, 30, 677-694. doi:10.1016/j.appdev.2009.01.003.
- Schmitt, S. A., Simpson, A. M., & Friend, M. (2011). A Longitudinal assessment of the home literacy environment and early language. *Infant and Child Development*, 20, 409-431. doi:10.1002/icd.733.
- van Steensel, R. (2006). Relations between socio-cultural factors, the home literacy environment and children's literacy development in the first years of primary education. *Journal of Early Childhood Literacy*, 6, 367-382. doi:10.1111/j.1467-9817.2006.00301x.
- Weigel, D. J., Martin, S. S., & Bennett, K. K. (2006). Mothers' literacy belief: Connections with the home literacy environment and pre-school children's literacy development. *Journal of Early Childhood Literacy*, 6, 191-211. doi:10.1177/14688798406066444.
- Wood, V. (2002). Parent-Child pre-school activities can affect the development of literacy skills. *Journal of Research in Reading*, 25, 241-258. doi:10.1111/1467-9817.00173.
- Wood, C., & Terrell, C. (1998a). Preschool phonological awareness and subsequent literacy development. *Educational Psychology*, 18, 253-274. doi:10.1111/0144341980180301.
- Wood, C., & Terrell, C. (1998b). Poor readers' ability to detect speech rhythm and perceive rapid speech. *British Journal of Developmental Psychology*, 16, 397-413. doi:10.1111/j.2044-835X.1998.tb.00760.x.

Family support and opportunity for early childhood literacy education

Turtohtokh.B, MNUE

Abstract

The fourth goal of Sustainable Development Goals is about quality education which is set down obtaining accredited education and supporting life-long learning opportunity. There are many factors that influence on forming life-span learning ability such as kindergarten, family and social environmental factors. The issue about early literacy has been discussed as school readiness, however, recent researchers increasingly concern about early literacy as top-priority skills to write and read. The paper will review the research conducted on home literacy environment and parents' supporting activities to early literacy and examine the Mongolian parental knowledge about early literacy skills of young children. The study was conducted in the form of a survey, with data being gathered via questionnaire in the range of content of 5 early literacy skills, such as phonological awareness, letter knowledge, print knowledge and print motivation, vocabulary and narrative skills. A random sample of parents with in-kindergarten and 5 years old children was recruited from Ulaanbaatar. The results of the survey were analyzed and reveal links between early literacy abilities and environment factors. The response rate was 55% of parents do some activities supporting early literacy skills with their young children, however parental knowledge about early literacy did not affect children's life-long learning opportunity. Enriched home literacy environment and parents' activity lead to preschoolers increased early literacy skills, which consequently results in preschoolers' proficiency of life-long learning. By investigating the predictive value of home literacy environment in early childhood on life-long learning skills, we attempted to make theoretical and empirical contributions to current knowledge of early literacy development.

Keywords

Early literacy, Early literacy skills, home literacy environment, parent's knowledge, parent's supporting activity